

2025 оны 08 сарын 01-ны өдөр

№ 18

Улаанбаатар хот

Тогтвортой хөгжлийн хороо байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 81 дүгээр 81.1 дэх хэсэг “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Тогтвортой хөгжлийн хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

1.1. Хорооны дарга – ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Цэлмэг

1.2. Хорооны гишүүн – ТУЗ-ийн ердийн гишүүн Н.Билгүүн

1.3. Хорооны гишүүн – ТУЗ-ийн ердийн гишүүн Л.Нарантуяа

2. Тогтвортой хөгжлийн хороог байгуулсантай холбоотойгоор Компанийн зохион байгуулалтын бүтэц баталсан 2022 оны 12 сарын 27-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 22/08 тоот тогтоолыг хүчингүйд тооцож, компанийн зохион байгуулалтын бүтцийг энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ



20 ~~25~~ оны 08 сарын 01 -ны өдөр

№ 19

Улаанбаатар хот

ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 81 дүгээр 81.1 дэх хэсэг “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд дараах өөрчлөлтийг оруулсугай.
 - 1.1. Журмын 10.1-т заасан ТУЗ нь Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Аудит, эрсдэлийн удирдлагын хороо гэсэн байнгын 3 хороотой байна” гэснийг
 - 1.2. ТУЗ нь Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Тогтвортой хөгжлийн хороо гэсэн байнгын 4 хороотой байна” гэж өөрчлөх.
2. Тогтвортой хөгжлийн хорооны үндсэн чиг үүргийг журмын 10.20-10.21 дэх хэсэгт дараах байдлаар нэмж оруулсугай.
 - 2.1. Журмын 10.20 дэх хэсэгт:

10.20 Тогтвортой хөгжлийн хороо нь 3-аас доошгүй гишүүнтэй байна.
 - 2.2. Журмын 10.21 дэх хэсэгт:

10.21. ТУЗ-ийн тогтвортой хөгжлийн хороо нь дараах чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар санал, шийдвэр боловсруулан ТУЗ-д танилцуулна. Үүнд:

 - 10.21.1. Тогтвортой байдал, байгаль орчин, нийгэм, засаглал, уур амьсгалын өөрчлөлтийн удирдлагын чиглэлээр компанийн бизнесийн үйл ажиллагаа болон түүний стратегид нэгтгэх бодлого, түүнд холбогдох дотоод журам, тогтолцоог боловсруулах, батлах, бодлогын хэрэгжилтийг хяналт тавих;
 - 10.21.2. Тогтвортой хөгжил, байгаль орчин, нийгэм, засаглал, уур амьсгалын өөрчлөлтийн удирдлагын чиглэлээр тэргүүлэх ажлын зорилтууд болон тэдгээрт хүрсэн гүйцэтгэлийн талаар хэлэлцэж, хяналт тавих ;
 - 10.21.3. Тогтвортой байдал, байгаль орчин, нийгэм, засаглал, уур амьсгалын өөрчлөлтийн удирдлагын чиглэлээрх тайлан, Гадаад аудит, хөндлөнгийн үнэлгээ эрсдэлийн талаар санал, зөвлөмжийг авч хэлэлцэх
 - 10.21.4. Тогтвортой хөгжил, байгаль орчин, нийгэм, засаглал, уур амьсгалын өөрчлөлтийн удирдлагын чиглэлээр нийтэд мэдээлэх тайланд хяналт тавих, санал зөвлөмж өгөх;
 - 10.21.5. Байгаль орчин, нийгэм, засаглалтай холбоотой эрсдэлийн талаар санал, зөвлөмж гаргах
 - 10.21.4. Шаардлагатай тохиолдолд тогтвортой байдал, байгаль орчин, нийгэм, засаглал, уур амьсгалын өөрчлөлтийн удирдлагын чиглэлээр Төлөөлөн удирдах зөвлөлд мэдээлэл, зөвлөмж хүргүүлэх.

3. Энэхүү шийдвэрийн 2-г заасан журмын нэмэлт өөрчлөлттэй холбоотой ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10.20-ыг 10.22; 10.21-ийг 10.23; 10.22-ыг 10.24; 10.23-ыг 10.25; 10.24-ыг 10.26; 10.25-ыг 10.27; 10.26-ыг 10.28; 10.27-ыг 10.29; 10.28-ыг 10.30; 10.29-ыг 10.31; 10.30-ыг 10.32 болгон тус тус дугаарлалтыг өөрчилсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 08 сарын 01 -ны өдөр

№ 20

Улаанбаатар хот

Компанийн зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн зохион байгуулалтын бүтцийг энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбоотойгоор 2022 оны 12 сарын 27-ны өдрийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 22/08 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, батлагдсан бүтцийн дагуу компанийн орон тоо батлах, хүний нөөцийг бүрдүүлэх ажлыг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ

